

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны дүгээр
сарын ... ны өдөр

Улаанбаатар хот

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дараахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт

“20.1.1.хүн амын унд, ахуйн хэрэгцээнд;
20.1.2.хонин толгойд шилжүүлснээр 300 толгой хүртэлх бэлчээрийн мал, 1 га хүртэлх тариа, ногооны талбайг услах;”

2 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Төлбөр ногдох ус” гэсэн хүснэгтийн 9 дэх заалтын “Газар тариалангийн үйлдвэрлэлд” гэснийг “Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд” гэж, 20 дугаар зүйлийн “20.1.2” дэх заалтын дугаарыг “20.1.3” гэж, “20.1.3” дахь заалтын дугаарыг “20.1.4” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.